



Эмч мэргэжилтэнүүдэд зориулан энэхүү гарын авлагын төслийг санаачлан, санхүүжүүлэн хэвлүүлсэн MCS Coca-Cola компанийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

“Хүүхдүүдийг маань эмч, багш, бусад чухал мэргэжилтэн зөв ойлгож, хүлээж авч, эцэг эхийг нь хүүхдээ буруу хүмүүжүүлсэн гэж зэмлэхгүй, хүүхдийг нь зөрүүд гэх мэт үгээр загнахгүй болсон, мэдлэг мэдээлэлд суурилсан өнөөгийн цаг үед энэ ном нь мэргэжилтнүүдийн хандлагыг өөрчлөхөөс гадна мэдлэгийг зузаатгаснаар Монголын аутизмтай хүүхдүүдэд үзүүлэх үйлчилгээг, тэр дундаа эрт илрүүлэлтийг улам сайжруулах нь гарцаагүй”

А.АМАРБУЯН

Монголын Аутизмын Холбооны  
тэргүүн



## БАГШ, ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН АУТИЗМЫН ТУХАЙ ГАРЫН АВЛАГА





## Autism Canada Message

We would like to thank the **Help Autism Now Society** for all the hard work they have put into this handbook and for so graciously allowing us to modify it to suit the needs of Canadians. It is an excellent resource to have, and the ability to add our distinctly Canadian content will only serve to make it more accessible and to help a far greater number of families.



Гарын авлагыг Канад Улсад хэвлүүлсэн Autism Canada ТББ-ын талархал

Нөр их хүчин чармайлт гарган энэхүү гарын авлагыг эмхэтгэн, Канадын иргэдэд зориулан өөрчлөн хэвлүүлэхийг бидэнд зөвшөөрсөн **Help Autism Now Society**-д чин сэтгэлийн талархал илэрхийлье. Энэ гарын авлага бол маш хэрэгтэй мэдлэгийн эх сурвалж бөгөөд канадчуудад зориулсан агуулга нэмж оруулсан нь илүү олон гэр бүлийн хэрэгцээнд нийцэж, тэдэнд туслах боломжийг бүрдүүлсэн юм.



## МОНГОЛЫН АУТИЗМЫН ХОЛБООНЫ ТУХАЙ

Монголын Аутизмын Холбоо 2014 онд аутизмтай хүүхэдтэй эцэг эхчүүдийн санаачлагаар байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Манай холбооны туйлын зорилго бол Монгол улсад аутизмтай хүүхэд, насанд хүрэгчидэд хамгийн ээлтэй орчинг бий болгоход хувь нэмрээ оруулах явдал юм. Бид эцэг эхчүүдийг чадавхжуулахад гол анхаарлаа хандуулдаг. Учир нь эцэг эхчүүд бол хүүхдийнхээ хувьд хамгийн ойр дотно, хамгийн сайн ойлгодог төдийгүй хүүхэддээ хамгийн сайн тусалж хамгаалж чаддаг гол хүмүүс байдаг.

Монголын Аутизмын Холбоо дараах зорилтуудын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

- Сургалт хийх, мэдээлэл өгөх, эх сурвалж хэрэглэгдэхүүнээр хангах, зөвлөгөө өгөх зэргээр эцэг эхчүүдийг дэмжих
- Аутизмтай хүүхэд, насанд хүрсэн хүн бүрийн боловсролын хүртээмжийг сайжруулах (тэгш хамруулах, тусгай сургалт), эрүүл мэндийн болон бусад үйлчилгээг сайжруулах
- Аутизмын эрт оношлогоо илрүүлэлтийг сайжруулах, эрт үеийн сургалт, засал, оролцоог нэмэгдүүлэх
- Аутизмын тухай ойлголтыг дэлгэрүүлэх, эерэг хандлагыг нийгэмд бий болгох
- Төрийн ба төрийн бус байгууллагуудтай дээрх зорилтуудаа хэрэгжүүлэхдээ хамтран ажиллах
- Олон улсын шилдэг тэргүүн туршлагыг Монголд нэвтрүүлэн нутагшуулахын тулд гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах
- Хот болон хөдөө орон нутгийн олон нийт, багш, эмч мэргэжилтнүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулж, аутизмын тухай мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, аутизмтай хүүхдүүдтэй харилцах арга зүй, тэдэнтэй ажиллах арга барил зөвлөгөө өгөх

# Гарчиг



Монголын Аутизмын Холбооны тухай	2
Гарчиг	3
Оношлох арга аргачлалууд	4
СНАТ танилцуулга	5
М-СНАТ-R оношлох аргачлал	6
<b>ЗАН ҮЙЛИЙН ИЛРЭЛҮҮД</b>	<b>8</b>
Нийгэмшихүйн хүндрэлүүд	8
Харилцааны хүндрэлүүд	11
Аутизмтай хүүхдийн давтагдмал зан үйл	12
Хөдөлгөөний эв дүй	16
Мэдрэхүйн хэт ачаалал	18
Мэдрэхүйн асуудлууд	19
Өөрийгөө гэмтээх үйлдлүүд	22
Аюулгүй байдал	23
Ходоод гэдэсний хямрал	26
Нойргүйдэл /Өвдөлтөд хариу үзүүлэх/ Таталт	27
Гэр бүлд үзүүлэх нөлөө	28
Эрт оролцооны ач холбогдол (Мэдлэг)	29
Мэргэжлийн бусад эмч нар	30
<b>АУТИЗМТАЙ ХҮҮХДЭД ҮЗЛЭГ ХИЙХЭД БЭЛТГЭХ ЗӨВЛӨМЖ</b>	<b>31</b>

## Аутизмын Хүрээний Эмгэгийг илрүүлэх

Аутизмын хүрээний эмгэг(АХЭ)-тэй хүүхдийг 18 сартайгаас нь эсвэл бүр түүнээс ч эрт илрүүлж, оношлох боломжтой байдгийг судлаачид олж тогтоожээ. Хүүхэд хоёр нас хүрэх үед туршлагатай мэргэжилтнээр оношлуулах нь хамгийн найдвартай гэж үздэг. Гэхдээ олон хүүхэд эцсийн оношлогоогоо үүнээс нэлээн хожуу хийлгэж байна. Ингэж хоцорч оношлуулах нь тухайн АХЭ-тэй хүүхдүүдэд туслах боломжийг огт ашиглахгүй өнгөрөөж байна гэсэн үг юм.

АХЭ-ийг эрт илрүүлэх тусам хүүхдэд зориулсан эмчилгээг эрт эхлүүлэх боломжтой. Илрүүлэх аргачлалууд нь хөгжлийн хоцрогдолтой байж болзошгүй хүүхдүүдийг зөвхөн таних л зориулалттай. Гэхдээ эдгээр илрүүлэх аргачлал нь хөгжлийн хоцрогдолтой гэдгийн баттай нотолгоо болдоггүйгээс гадна шууд онош тогтоох үндэслэл болохгүй. Харин доор дурдагдах арга аргачлалын дагуу хөгжлийн хоцрогдолтой байж болзошгүй гэж тодорхойлогдсон хүүхдийг нэн даруй энэ төрлийн мэргэжилтэнд үзүүлэх шаардлагатай гэсэн үг юм.

### Эрт илрүүлэх аргачлалууд

Хөгжлийн хоцрогдлыг илрүүлэх олон аргачлал бий. Тухайлбал, 2 хүртэл насны хүүхдэд, бага насны хүүхдэд, өсвөр насныханд, насанд хүрэгчдэд ашиглах гэх мэт насны ангиллаас хамаарсан 4 аргачлал байдаг.

Аль аргачлалыг ашиглаж байгаагаас хамааран илрүүлэх үзлэгийг энэ төрлийн мэргэжилтэн хийхээс гадна зарим тохиолдолд нийгмийн ажилтан, цаашлаад эцэг эхүүд ч өөрсдөө хийж болдог.

Илрүүлэх арга аргачлалуудын заримаас дурдвал:

- Ages and Stages Questionnaires (ASQ)
- Communication and Symbolic Behavior Scales (CSBS)
- Parent's Evaluation of Development Status (PEDS)
- Checklist for Autism in Toddlers (CHAT)
- Modified Checklist for Autism in Toddlers (M-CHAT)
- Modified Checklist for Autism in Toddlers, Revised (M-CHAT-R)
- Pervasive Developmental Disorder Screening Test-II (PDDST II)
- Screening Tool for Autism in Toddlers and Young Children (STAT)

Дээр дурдсанаас гадна өөр арга аргачлалууд бас бий.


Энэхүү гарын авлагад CHAT аргачлалын зурагт хуудас, мөн M-CHAT-R асуумжийг оруулсан болно.

# M-CHAT-R (Modified Checklist for Autism in Toddlers, Revised)

## 18 сартайдаа таны хүүхэд...



1. Танд ямар нэгэн юм үзүүлэхийг хүссэн үедээ **тан руу харж, үзүүлэх гэсэн юм руугаа хуруугаараа заадаг** уу?



2. Таны **заасан зүг рүү** дагуулж **хардаг** уу?



3. **Төсөөллөө** ашиглан **айл гэр** болж тоглодог уу?

Хэрэв **ҮГҮЙ** гэж хариулсан бол танай хүүхэд **АУТИЗМ**-тай байж болзошгүй

CHAT (CHecklist for Autism in Toddlers) аргачлалыг ашиглае

# M-CHAT-R (Modified Checklist for Autism in Toddlers, Revised)

1-р нүүр (18 сартай үеийн үзлэгээр бөглөнө)

## 1-Р ХЭСЭГ: ЭЦЭГ ЭХИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ

Таны хүүхдийн тухай асуух дараах асуултуудад хариулна уу. Таны хүүхэд ер нь ямар зан үйлдэл гаргадаг талаар бодоорой. Хэрэв таны хүүхэд дурдсан үйлдлийг ганц нэг удаа хийдэг ч, байнга хийдэггүй бол үгүй гэж хариулаарай. Бүх асуултанд хариулна уу.

01. Өрөөний нөгөө булан руу та хуруугаараа заахад таны хүүхэд дагуулж хардаг уу? (Жишээлбэл, хэрэв та тоглоом эсвэл амьтны зүг заавал, таны хүүхэд тэр тоглоом эсвэл амьтан руу харах уу?)	Yes	No
02. Та хүүхдээ дүлий юм биш биз гэж бодож байв уу?	Yes	No
03. Таны хүүхэд айл гэр болж тоглодог уу? (Жишээлбэл, хоосон аяганаас юм уух, утсаар ярьж байгаа мэт дүр эсгэх, хүүхэлдэй эсвэл чихмэл тоглоомоо хооллох г.м.)	Yes	No
04. Таны хүүхэд дээш авирах дуртай юу? (Жишээлбэл, тавилга, хүүхдийн тоглоомын талбайн авирдаг тоглоомнууд, шат гэх мэт)	Yes	No
05. Таны хүүхэд нүд эсвэл чихнийхээ ойролцоо гарын хуруунуудаа хөдөлгөдөг сонин үйлдэл хийдэг үү? (Жишээлбэл, нүднийхээ өмнө хуруугаа агаарт хий хөдөлгөх г.м.)	Yes	No
06. Таны хүүхэд ямар нэгэн юм асуух, эсвэл тусламж хүсэхдээ тухайн зүйл рүүгээ нэг хуруугаараа заадаг уу? (Жишээлбэл, хүрч чадахгүй байгаа идэх юм эсвэл тоглоомоо танаар авахуулах гэж гуйхдаа)	Yes	No
07. Таны хүүхэд ямар нэгэн сонирхолтой зүйлийг танд үзүүлмээр байгаа үедээ нэг хуруугаараа заадаг уу? (Жишээлбэл, нисч байгаа онгоцыг эсвэл замаар явж байгаа том ачааны машиныг “хар даа” гэж заах)	Yes	No
08. Таны хүүхэд өөр хүүхдийг сонирхдог уу? (Жишээлбэл, бусад хүүхдүүдийг тоглож байгааг харах, тэдэн рүү инээмсэглэх, дөхөж очих г.м.)	Yes	No
09. Таны хүүхэд тоглоомоо танд авчирч үзүүлдэг үү? Танаар туслуулах гэсэндээ бус зүгээр л хуваалцах гэж. (Жишээлбэл, цэцгээ авчирч үзүүлэх, чихмэл амьтан эсвэл тоглоомон машинаа үзүүлэх г.м.)	Yes	No
10. Таны хүүхэд нэрээр нь дуудахад хариу үйлдэл үзүүлдэг үү? (Жишээлбэл, дуудахад наашаа харах, ярих эсвэл ганганах, хийж байгаа зүйлээ орхих г.м.)	Yes	No
11. Таныг хүүхэд рүүгээ хараад инээмсэглэх үед тэр хариу инээмсэглэдэг үү?	Yes	No
12. Таны хүүхэд өдөр тутмын дуу чимээнд тавгүйддэг үү? (Жишээлбэл, тоос сорогч эсвэл чанга хөгжим г.м.)	Yes	No
13. Таны хүүхэд хөлд орсон уу?	Yes	No
14. Хүүхэдтэйгээ ярьж байхад, эсвэл хамт тоглож байхад, хувцсыг нь өмсүүлж байхад таны хүүхэд таны нүд рүү хардаг уу?	Yes	No
15. Таны хүүхэд таны хөдөлгөөнийг дууриаж, давтаж хийдэг үү? (Жишээлбэл, баяртай гэж гараа даллах, алгаа таших, таныг дууриаж инээдтэй дуу авиа гаргах)	Yes	No
16. Та ямар нэгэн зүйл харахаар толгойгоо эргүүлэхэд таны хүүхэд таныг юу руу харсныг олж мэдэхээр тэр зүг рүү мөн хардаг уу?	Yes	No
17. Таны хүүхэд таныг өөр лүүгээ харуулахыг оролддог уу? (Жишээлбэл, магтуулахаар тан руу харах, эвсэл “наашаа хар даа”, “намайг хар даа” гэж хэлдэг үү?)	Yes	No
18. Таны хүүхэд таныг юм хэлэхэд ойлгоод хийдэг үү? (Жишээлбэл, гараараа заахгүйгээр “Номоо сандал дээр тавь” эсвэл “надад бүтээлэг аваад ир” гэж хэлбэл ойлгох уу?)	Yes	No
19. Хэрэв өмнө нь болж байгаагүй зүйл тохиолдвол таны хүүхэд таны нүүр лүү харж, таныг юу гэж бодож байгааг мэдэх гэж оролддог уу? (Жишээлбэл, хэрэв таны хүүхэд сонин жигтэй дуу чимээ сонсвол эвсэл шинэ тоглоом харвал, таны нүүр лүү харах уу?)	Yes	No
20. Таны хүүхэд хөдөлгөөнд дуртай юу? (Жишээлбэл, савлуулах, хүний өвөр дээр үсрэх г.м.)	Yes	No



# M-CHAT-R (Modified Checklist for Autism in Toddlers, Revised)



2-р нүүр

## ДҮГНЭХ АРГА

Аутизмын хүрээний эмгэгийг илэрхийлэх “Үгүй” хариулт:  
2, 5 ба 12-р асуултаас бусад бүх асуулт

Аутизмын хүрээний эмгэгийг илэрхийлэх “Тийм” хариулт:  
2, 5 and 12-р асуултууд

## ОНООЛТ

АХЭ-тэй байх өндөр эрсдэлтэй	8-20 оноо
АХЭ-тэй байх дундаж эрсдэлтэй	3-7 оноо
АХЭ-тэй байх бага эрсдэлтэй	0-2 оноо

## ЗӨВЛӨМЖ:

### ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ:

Тухайн орон нутгийнхаа аутизмын талаар мэргэшсэн хүүхдийн эмч, хүүхдийн хөгжлийн төвд хандана уу.

### ДУНДАЖ ЭРСДЭЛТЭЙ:

Дагалдах тандалт оношлогоог авч хэрэгжүүлнэ үү.  
([www.mchatscreen.com](http://www.mchatscreen.com) цахим хуудсан дээр бий).


Хэрэв оноо 2-с дээш хэвээр байвал Өндөр эрсдэлтэй бүлэгт орно.

Хэрэв оноо 2-с доош байвал бага эрсдэлтэй бүлэгт тооцогдоно. Хүүхдийг ирээдүйд оношлуулах нь зүйтэй.

### БАГА ЭРСДЭЛТЭЙ:

Хэрэв таны хүүхэд 24 сар хүрээгүй бол 2 насны төрсөн өдрийнх нь дараа дахин үнэлүүлнэ үү. АХЭ-ийн шинж тэмдгүүд ажиглагдаагүй бол санаа зовох зүйлгүй

## Аутизмын зан үйлийн шинж тэмдэг



**Нийгэмшихүй**

**Харилцаа**

**Аутизмын давтагдмал  
зан үйл**

**Хөдөлгөөн**

**Мэдрэхүйн хэт ачаалал**

**Мэдрэхүй**

**Өөрийгөө гэмтээх үйлдэл**

**Аюулгүй байдал**





## НИЙГЭМШИХҮЙН ХҮНДРЭЛҮҮД

Бусад хүүхдүүдтэй хамт тоглох сонирхолгүй байх



Ах дүү нартаа  
ширүүн харьцах

Ээжийгээ дуудахын  
оронд ганцаараа орилж  
уйлах



Эцэг эх нь ажилдаа  
явах эсвэл ажлаасаа  
ирэхийг анзаарахгүй  
байх



## НИЙГЭМШИХҮЙН ХҮНДРЭЛҮҮД

Идэвхтэй харилцаа  
шаардсан тоглоом  
(нуугдаж тоглох г.м.)  
тоглох огт сонирхолгүй



Тэврүүлэх, үнсүүлэх  
дургүй



Орноос нь тэвэрч  
авах гэхэд гараа тосч  
сарвайхгүй байх



## ХАРИЛЦААНЫ БЭРХШЭЭЛҮҮД

Аутизмтай хүүхдүүд хүрээлэн буй орчинд нь юу болж байгааг анзаарахгүй байгаа мэт байдаг. Мөн хүний нүд рүү харахаас зайлсхийнэ. Энэ нь ихэнх хүмүүст тухайн хүүхэд харилцах ямар ч сонирхолгүй байгаа мэт ойлгогддог. Хэрэв тэдэнд ямар нэгэн зүйл хэрэгтэй болбол тэд ихэвчлэн том хүнийг “гараар нь чиглүүлдэг”. Ингэхдээ авахыг хүссэн зүйл дээрээ эцэг эхийнхээ гарыг аваачих буюу хэрэгцээгээ хангахад ашиглах ХЭРЭГСЭЛ болгодог. Харин хэвийн хөгжилтэй хүүхэд энэ тохиолдолд хэл яриагаар ойлгуулах, эсвэл хуруугаараа заах гэх зэргээр ойлгуулдаг байна.



Эргэн тойронд нь юу болж байгааг анзаарахгүй байх




Нүд рүү харахаас зайлсхийх

Хүний гарыг чиглүүлэх





## АУТИЗМЫН ДАВТАГДМАЛ ЗАН ҮЙЛ



Гараа сарвагануулах



Таазны сэнсийг харж гөлрөх



Дороо эргэлдэх

Тоглоомнуудаа нэг эгнээнд өрөх



## АУТИЗМЫН ДАВТАГДМАЛ ЗАН ҮЙЛ



Тоглоомонд сонирхолгүй  
хэрнээ нэг зүйлийг хэт  
туйлшран сонирхох

Нарны туяанд  
бужигнах  
тоосонцорыг барих  
гэж оролдох



Тоглоомын зөвхөн нэг  
хэсэгт хэт татагдах.  
Жишээ нь, дугуйг нь  
эргэлдэхийг харах



## АУТИЗМЫН ДАВТАГДМАЛ ЗАН ҮЙЛ



Биеэ урагш хойш савлах



Гэрлийг дахин дахин  
унтрааж асаах



Хөшиг, даавуу гэх мэт эд  
зүйлсийг идэх



Нүднийхээ  
өмнө  
хуруугаа  
агаарт хий  
хөдөлгөх



## АУТИЗМЫН ДАВТАГДМАЛ ЗАН ҮЙЛ

Бие дээрээ  
даралт мэдрэх



Баасаараа тоглох



Хүчтэй доргилт  
мэдрэх дуртай





## ХӨДӨЛГӨӨНИЙ ЭВ ДҮЙ

Аутизмтай хүүхдүүд нь хөдөлгөөний өвөрмөц байдалтай байдаг. Зарим нэг зүйл дээр маш сайн чадвартай байдаг ч, бусад чадвар нь сул байдаг байна.



Жижиг булчингийн хөгжил сул



Биеийн хэсгүүдээ жигд зэрэг удирдан зохицуулахдаа муу



Өлмий дээрээ явдаг



Орон зайн баримжаа сул

# Аутизмын зан үйлийн шинж тэмдэг



## ХӨДӨЛГӨӨНИЙ ЭВ ДҮЙ

Энгийн дасгал хөдөлгөөнийг хийж чаддаг ч гэлээ гурван-дугуйт унах, тоглоомон машин дээр сууж явж чаддаггүй.



Гурван дугуйт болон тоглоомон машин унаж чаддаггүй





## МЭДРЭХҮЙН ХЭТ АЧААЛАЛ



Аутизмтай хүүхэд нь хөгжим, дуу чимээг, зарим зүйлд хүрэлцэхийг, эсвэл шинэ орчинд орохыг тэвчиж чаддаггүй байх нь элбэг. Хэр их олон ийм таагүй зүйлд өртөнө, тэр хэмжээгээр хямрах магадлал нэмэгдэнэ.

## МЭДРЭХҮЙН АСУУДЛУУД

Үсийг нь засуулах маш  
хүндрэлтэй



Суудлын  
бүсийг  
тэвчиж  
чаддаггүй



Төрсөн өдрийн  
бялуун дээрх лаа,  
өнгө өнгийн шаар гэх  
мэт шинэ зүйлсийг  
дуртай хүлээж  
авдаггүй



Усанд орох дургүй





## МЭДРЭХҮЙН АСУУДЛУУД

Гэр ахуйн зарим үнэрт  
огидог



Хөгжим сонсохыг  
тэвчиж чаддаггүй



Нүүрэндээ тулгаж  
байгаад юм  
эргүүлдэг



Дүлий юм шиг байх,  
чанга чимээнд  
цочихгүй байх  
атлаа бусад үед  
сонсгол нь хэвийн

## МЭДРЭХҮЙН АСУУДЛУУД




Өвлийн улиралд гадуур хувцсаа өмсөхгүй эсвэл тайлах гээд байх

Хувцсаа солихгүй гэж зүтгэх



Өөрийнхөө хувцсыг урах, оёдлоор нь ханзлах

Зун болж байхад өвлийн хувцас өмсөнө гэж зүтгэх



## ӨӨРИЙГӨӨ ӨВТГӨХ ҮЙЛДЛҮҮД




Толгойгоороо юм мөргөх

Өөрийгөө хазах,  
өвдөлт огт  
мэдрэхгүй байгаа  
юм шиг байх



Арьсаа урж  
шалбалах




Үсээ туг  
тугаар нь  
зулгаах





АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДЛУУД



Аюулыг мэдрэхгүй байх






АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Өөрийг нь гэмтээх эрсдэлтэй зүйлийг мэдэхгүй байх





АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Өндрөөс айхгүй байх



## Хоол боловсруулах эрхтний хямрал




Харвардын их сургуулийн Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны багш, Бостоны Масс Женерал эмнэлгийн эмч **Доктор Тим Бю** нь аутизмтай 1000 гаруй хүүхдэд ходоодны дурангаар шинжилгээ хийжээ. Эхний 400 хүүхдэд хийсэн шинжилгээгээр аутизмтай хүүхдүүдэд хоол боловсруулах, гэдэс дотрын өвчин ердийн хүүхдүүдээс илүү түгээмэл байдгийг олж мэджээ.

- 20% Улаан хоолойн үрэвсэл
- 12% Ходоодны үрэвсэл
- 12% Бүдүүн гэдэсний үрэвсэл
- 55% Лактаза ферментийн дутагдал
- 10% Доод гэдэсний үрэвсэл

**Шаардлагатай тохиолдолд хоол боловсруулах эрхтний эмчид үзүүлээрэй.**



Гүйлгэх



Өтгөн гүйцэт боловсроогүй байх



Цөөхөн хэдэн төрлийн хоол л идэх буюу Хүнсэнд хэт мэдрэмтгий болох



Өтгөн хатах

## Нойргүйдэл/Өвдөлтөнд хариу үзүүлэх/Таталт



### НОЙРГҮЙДЭЛ

Нойр нь хүрэхгүй байх, бүр хэдэн өдрөөр ч унтахгүй сэрүүн байх, өдөр шөнийг ялгахгүй болох, унтуулахад хэцүү, унтсан үедээ амархан сэрж сэвэгнэх, түрхэн хугацаанд (1-2 цаг) унтаад сэрдэг гэх мэт. Үүний үр дүнд **эцэг эхчүүд нойрны дутагдалд орох** нь бий.



### ӨВДӨЛТӨНД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ

Өвдөлтөнд хариу үйлдэл бага үзүүлэх /огт үзүүлэхгүй байх/ эсвэл  
Өвдөлтөнд хэт их мэдрэмтгий байх



### ТАТАЛТ

Таталт болон түүнтэй хавсарсан өвчлөл, нас ахих тусам нэмэгддэг. Шалтгаан нь тодорхойгүй.

## Impact of Autism on the Family



**АУТИЗМТАЙ ХҮҮХЭДТЭЙ БОЛ ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЗҮЙЛС  
САНАСНААР БОЛОХГҮЙ БАЙХ ТОХИОЛДОЛ ЗӨНДӨӨ ГАРДАГ**

Аутизмтай хүүхэдтэй ээж аав, тэр бүү хэл ах, эгч, дүү нар нь сэтгэлийн дарамтанд их ордог. Гэр бүлийн гишүүн бүрт сэтгэл зүйн зөвлөгөө авахыг, бие биеэ сэтгэл санаагаар дэмжих бүлгүүдэд хамрагдахыг зөвлөх хэрэгтэй.

## Эрт үеийн оролцооны ач холбогдол



Эрт үеийн оролцооны үр дүнд хүүхэд болон гэр бүлийн аль аль нь сайжирдаг гэдгийг судалгаагаар тогтоосон байдаг. Эхний ээлжинд, хүүхдэд ойр тойронд нь юу болж байгааг анзаарахыг сургах, бусдыг даган дуурайх, дараа нь харилцааны чадвараа сайжруулах зэргийг заадаг ажээ.



Аливаа хүүхдэд хөгжлийн хоцрогдол ажиглагдвал эцэг эхэд нь Эрт үеийн оролцоо (Early Intervention)-ны үнэлгээнд хамрагдахыг зөвлөөрэй. Хүүхдийн хэрэгцээ шаардлагаас хамаарч Эрт Үеийн Оролцоо нь хэл ярианы чадварыг дээшлүүлэх, өөртөө үйлчлэх чадвар суулгах болон хөдөлгөөн засал гэх мэт олон янз байдаг.

## Хандах мэргэжилтнүүд



1. Хүүхдийн эмч, хүүхдийн сэтгэл зүйн эмч, хүүхдийн өсөлт хөгжлийн мэргэжилтэн
2. Хүүхдийн гэдэс дотрын мэргэжилтэн (ихээр гүйлгэх, өтгөн хатах, цустай өтгөн гаргах, гүйцэт боловсроогүй өтгөн гаргах тохиолдолд)
3. Мэдрэлийн эмч (хэрэв таталт өгдөг бол)
4. Сонсгол шалгуулах
5. Хэл засалч
6. Ахуй / Хөдөлгөөн засалч
7. Хоол тэжээлийн мэргэжилтэн
8. Хараа Зүйч (харааны засал)
9. Бариац эсвэл нуруу нугасны уламжлалтын эмч
10. Хөгжим ба тоглоомын засалч
11. Нийгмийн ажилтан / Гэр бүлийн зөвлөгөө



## Аутизмтай хүүхдэд үзлэг хийхэд бэлтгэх



Эмч нарт өвчнийг хайж олох ёстой гэж сургадаг. Гэтэл аутизмтай хүүхдүүд өвчтэй юм шиг харагддаггүй. Тэд эв эрүүл харагдаж, эрүүл хүүхдийн биеийн хөгжлийн бүхий л үзүүлэлтийг хангасан байдаг.



Тэд хүмүүжилгүй, ээж аавынхаа үгэнд ордоггүй дураараа хүүхэд шиг аашилж магадгүй. Тэд **шинэ орчин, танихгүй хүн**, өмнө нь **хийж байгаагүй зүйлд дургүй**. Ер нь л өөрчлөлтөнд дургүй.





## ЭЦЭГ ЭХТЭЙ НЬ ҮЗЛЭГЭЭС ӨМНӨ УТСААР ЯРИЛЦАЖ ЗӨВЛӨХ

**Ингэснээр** дараах боломж үүснэ.  
Үүнд:


1. Хажууд хүүхэд байхгүй үед эцэг эхтэй нь тухтай ярилцах,
2. Эцэг эхээс нь үзлэгийн үеэр юунд анхаарах талаар лавлах,
3. Үзлэгийн үеэр хүүхдийг урамшуулан өгөх шагнал авчрахыг эцэг эхэд нь захих,
4. Хэрэв цусны шинжилгээ авах шаардлагатай бол өвчин намдаах түрхлэгийг үзлэг эхлэхээс өмнө түрхэх, үүний тулд урьдчилан жор бичиж өгөх,
5. Эцэг эхчүүдийг хүүхдээ эмнэлэгт дагуулж ирэхээсээ өмнө хүүхэддээ эмчид үзүүлэх, мөн цусны шинжилгээ өгөх талаар жижиг түүхүүдийг ярьж өгч, хүүхдийн сэтгэл зүйг бэлтгэхийг зөвлөх ([helpautism-now.com](http://helpautism-now.com) цахим хуудсан дээр бий)



## ЭЦЭГ ЭХИЙГ АНХААРАЛТАЙ СОНСОХ

Эцэг эх нь хүүхдээ “унших” буюу ойлгох талаар хамгийн сайн мэдлэгтэй байдаг.

Хэрэв боломжтой бол өвчний шинж тэмдгийг нь ямар ч хүүхдийг эмчлэхээс ялгаагүй эмчлээрэй (таны гаргах эмчийн дүгнэлтэнд “аутизм” нөлөөхгүй байлгахыг хичээгээрэй)



## Аутизмтай хүүхдэд үзлэг хийхэд бэлтгэх



### ҮЗЛЭГИЙН ӨРӨӨГ УРЬДЧИЛАН БЭЛТГЭХ

Сувилагч эсвэл эмчийн туслах нь хүүхдийн эцэг эхтэй үзлэгийн өрөөнд юу юу бэлтгэх талаар зөвлөлдөж байх чухал. Тухайлбал:

- Дуу чимээ багатай өрөө
- Цонхгүй өрөө
- Тод гэрэлгүй өрөө
- Хөгжим тавихгүй байх г.м.

Хэрэв шаардлагатай бол хурц үзүүртэй, хүн бэртээхээр зүйлсийг өрөөнөөс гаргах хэрэгтэй.



### ХҮЛЭЭЛГИЙН ХУГАЦААГ АЛЬ БОЛОХ БОГИНО БАЙЛГАХ

#### Бодолцох зүйл:

Хүлээлгийн өрөөнд байх нь маш стресстэй бөгөөд хэцүү байж болно. Аутизмтай хүүхдийг өглөө хамгийн эхэнд эсвэл өдрийн хүн цөөн байдаг цагуудад үзэх нь зөв.

**Ингэснээр** дараах эрсдлүүдийг багасгана. Үүнд:

1. Хүүхэд хямрах
2. Хүлээлгийн өрөөнд байгаа бусад хүнийг тавгүйтүүлэх
3. Эцэг эх нь эвгүй байдалд орох
4. Хүлээлгийн өрөөг эвдэх, сүйтгэх

Хүүхдийг үзэх цагаа урьдчилан утсаар ярьж төлөвлөх хэрэгтэй.



## Аутизмтай хүүхдэд үзлэг хийхэд бэлтгэх



### ХАРАГДАЖ БАЙГАА ШИГЭЭ БАЙДАГГҮЙ


Хэдийгээр хүүхэд анхаарлын гадна үлдсэн, хүчийрхийлэлд өртсөн юм шиг харагдавч дараах зүйлсийг санаарай. Үүнд:

Өөрийгөө гэмтээх зан үйл гаргадаг, тухайлбал хазах, толгойгоороо юм мөргөх, арьсаа маажиж шалбалах г.м.

Өвчин мэдрэх нь бага, хязгаарлагдмал, эсвэл бүр огт мэдэрдэггүй

Өөрийг нь гэмтээх аюултай зүйлээс эмээдэггүй.

Хэт мэдрэхүйн хүндрэлээс болж хувцсыг нь солиход эсвэл усанд оруулахад маш хэцүү, бараг боломжгүй



### ЮУНД БЭЛЭН БАЙХ ВЭ

#### Өөрийн аюулгүй байдалд анхаарч, сонор сэрэмжтэй бай

Зарим аутизмтай хүүхэд таныг тэдэнд туслах гэж байгааг ойлгохгүй, харин ч таныг аюултай гэж бодож магадгүй юм. Тэд тайван байж байгаад нэг харахад таныг

- мөргөх
- хазах
- өшиглөх
- нулимах
- тургих
- үсийг тань зулгаах
- огло харайх

гэх зэрэг олон байдлаар гэмтээж болно.



Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд та хүүхдийн хувийн орон зайд битгий халдаарай.

(орон зай нь таны бодсоноос том байж болзошгүй)


## Аутизмтай хүүхдэд үзлэг хийхэд бэлтгэх



### ОЙЛГОХ БА ЯРИХ ЧАДВАР СУЛ

Зарим хүүхэд Disney-н хүүхэлдэйн киноны яриаг бүтнээр цээжээр дуржигнуулах ч гэлээ нэрээ хэлж чадахгүй, эсвэл өвдөж байгаагаа хэлж чадахгүй байх нь бий.

Зарим нь сонссон яриагаа боловсруулж ойлгохдоо муу байдаг.



### ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨГ БОДОЛЦОХ

Шаардлагатай тохиолдолд аутизмтай хүүхэдтэй гэр бүлд санал болгох зүйлс:

- Ах дүү нарт зориулсан семинар
- Гэр бүлүүд бие биенээ дэмжих группд нэгдэх
- Хүүхэд харах үйлчилгээ





Autism Association  
of Mongolia

**МОНГОЛЫН АУТИЗМЫН ХОЛБОО**

**Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо**

**Дунд гол гудамж, 30а байр 32 тоот**

**Утас: 9913-8914, 9185-9191**

**Email: [autismassociationmongolia@gmail.com](mailto:autismassociationmongolia@gmail.com)**

**[www.autism.mn](http://www.autism.mn)**



